



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2011 оны 09 сарын 14 өдөр

Дугаар 263

Улаанбаатар хот

Г “Хуртай” ХК-ийн үнэт цаасны 7
арилжааг сэргээх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.1, 6.2.2, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 34.1.1, Санхүүгийн зохицуулах хорооны 2008 оны 77 дугаар тогтоолын 4.1 дэх хэсгийг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Хуртай” ХК-ийн үнэт цаасны арилжааг 2011 оны 9 дүгээр сарын 19-ний өдрөөс эхлэн сэргээсүгэй.
2. “Хуртай” ХК-ийн хувьцааг арилжаалж эхлэхийг “Монголын хөрөнгийн бирж” ХК /Х.Алтай/, үнэт цаасны арилжааны төлбөр тооцоо гүйцэтгэхийг “ҮЦТТТХТ” ХХК /Т.Гандулам/-д тус тус зөвшөөрсүгэй.
3. 2011 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор “ҮЦТТТХТ” ХХК дахь данс нь нээгдээгүй байгаа хувьцаа эзэмшигчдийн дансыг компанийн санхүүжилтээр нээлгэхийг “Хуртай” ХК /Ц.Ламжав/-д үүрэг болгосугай.
4. “Хуртай” ХК-ийн хувьцаа эзэмшигч Ц.Ламжав, Ц.Нанзаддорж, Н.Цогтгэрэл нарын өмчилж байгаа үнэт цаасны “Хуртай” ХК-ийн нийт 54800 ширхэг хувьцааг 2011 оны 9 дүгээр сарын 19-ний өдрөөс эхлэн нэг жилийн хугацаатайгаар тусгаарлахыг “ҮЦТТТХТ” ХХК /Т.Гандулам/-д үүрэг болгосугай.
5. Энэ тогтоолын 4 дэх заалтаар тусгаарлалт хийсэн нь нэр дурдагдсан 3 хувьцаа эзэмшигчдийн хооронд үнэт цаасны өмчлөх эрхийг шилжүүлэх ажиллагааг хязгаарлахгүй болохыг тэмдэглэсүгэй.
6. Санхүүгийн зохицуулах хорооны 2007 оны 210 дугаар тогтоолоор батлагдсан “Монголын компанийн засаглалын кодекс”-т заасан дотоод баримт бичгийг боловсруулан 2011 оны 4 дүгээр улиралд багтаан ирүүлэх, мөн оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Үнэт цаасны зах зээлийн мэдээллийн нэгдсэн сангийн тухай журам”-д заасан мэдээллийг цаг тухайд нь тогтмол ирүүлж хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ чанд биелүүлэн ажиллахыг “Хуртай” ХК /Ц.Ламжав/-д анхааруулсугай.
7. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Үнэт цаасны газар /С.Тулгаа/, олон нийтэд мэдээлэхийг Тамгын газар /Н.Туул/-т тус тус даалгасугай.

ДАРГА

Д. БАЯРСАЙХАН